



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/254-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16-17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17-18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20-21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.21 № *СЭА-2022/254-НА-СТА-ТШЗ*
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	172,925,866.06	165,703,455.80
33	АВЛАГА	799,397.00	799,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	122,742.00	122,742.00
335	Бусад авлага	676,655.00	676,658.00
3351	Байгууллагаас авах авлага	676,655.00	676,658.00
35	БАРАА МАТЕРИАЛ	172,126,469.06	164,904,055.80
351	Түүхий эд материал	22,653,460.64	21,912,062.49
35130	Эм боох материал	22,653,460.64	21,912,062.49
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,065,520.53	606,350.53
354	Хангамжийн материал	146,407,487.89	142,385,642.78
35410	Бичиг хэргийн материал	6,435,105.00	7,598,760.00
35420	Аж ахуйн материал	844,441.00	844,441.00
35440	Түлш, шатах тослох материал	4,490,000.00	9,775,000.00
35470	Бусад хангамжийн материал	134,637,941.89	124,167,441.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	108,206,706.58	225,624,777.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	108,206,706.58	225,624,777.09
392	Биет хөрөнгө	70,094,044.53	189,019,159.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	37,325,333.43	37,325,333.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,257,036.57)	(21,375,803.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,418,399.85	248,418,399.85
39204	Хуримтлагдсан элэгдэл	(212,418,399.85)	(225,594,011.85)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	360,173,697.16	482,821,937.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(335,251,457.88)	(357,299,690.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,407,464.72	41,725,364.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,103,956.33)	(33,982,553.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,537,752.84	18,743,752.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,737,752.84)	(1,763,569.22)
393	Биет бус хөрөнгө	38,112,662.05	36,605,617.27
39301	Программ хангамж	8,693,000.00	8,793,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,624,337.95)	(6,231,382.73)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,044,000.00	34,044,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	281,132,572.64	391,328,232.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	378,500.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	378,500.00	-
413	Өглөг	378,500.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	378,500.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	280,754,072.64	391,328,232.89
51	Засгийн газрын хувь оролцоо	280,754,072.64	391,328,232.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	451,495,666.98	451,495,666.98
51101	Өмч: - төрийн	451,495,666.98	451,495,666.98
512	Хуримтлагдсан үр дүн	(183,510,977.25)	(72,936,817.00)
51210	Өмнөх үеийн үр дүн	(307,469,888.32)	(183,510,977.25)
51220	Тайлант үеийн үр дүн	123,958,911.07	110,574,160.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,769,382.91	12,769,382.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	281,132,572.64	391,328,232.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,357,958,680.00	1,274,451,043.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,426,080.00	182,775,389.50
120	Нийтлэг татварын бус орлого	120,426,080.00	182,775,389.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	120,426,080.00	181,445,229.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,956,200.00	20,594,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	100,469,880.00	160,850,929.50
120009	Бусад орлого	-	1,330,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,237,532,600.00	1,091,675,654.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,237,532,600.00	1,091,675,654.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,006,099,100.00	931,258,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,500,000.00	1,256,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	199,933,500.00	155,160,554.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,233,972,241.90	1,163,876,883.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,233,972,241.90	1,163,876,883.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	857,380,497.45	895,634,530.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	559,483,040.67	562,540,767.38
210101	Үндсэн цалин	478,200,515.74	397,651,329.26
210102	Нэмэгдэл цалин	74,455,088.93	144,258,381.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,827,436.00	14,007,000.03
210104	Урамшуулал	-	6,624,056.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,450,643.88	74,035,701.20
210201	Тэтгэврийн даатгал	48,287,115.36	52,054,736.52
210202	Тэтгэмжийн даатгал	5,721,188.54	5,791,824.28
210203	ҮОМШ өвчний даатгал	4,164,319.69	4,522,579.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,433,273.49	1,060,596.37
210205	Эрүүл мэндийн даатгал	10,844,746.80	10,605,964.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,638,622.00	45,549,014.00
210301	Гэрэл цахилгаан	7,673,896.00	9,852,243.00
210302	Түлш, халаалт	22,315,600.00	19,806,431.00
210303	Цэвэр, бохир ус	1,979,926.00	2,221,140.00
210304	Байрны түрээс	13,669,200.00	13,669,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,912,372.00	50,413,345.00
210401	Бичиг хэрэг	7,362,900.00	8,260,275.00
210402	Тээвэр шатахуун	30,770,000.00	28,475,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,192,860.00	8,242,260.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,200.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,498,412.00	5,342,210.00
2105	Нормативт зардал	12,668,176.39	10,254,916.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,896,476.39	8,574,366.85
210502	Хоол, Хүнс	3,771,700.00	1,680,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,113,774.00	63,404,504.91
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	40,340,924.00	32,689,950.91
210604	Урсгал засвар	16,772,850.00	30,714,554.00
2107	Томилолт, зочны зардал	36,656,900.00	27,387,300.00

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	36,656,900.00	27,387,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,243,066.00	15,086,712.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,217,800.00	12,000,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	122,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	272,550.00	295,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	737,266.00	487,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	792,000.00	814,462.00
210807	Газрын төлбөр	28,390.00	32,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	772,060.00	1,235,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,213,902.51	46,962,269.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,028,400.00	1,108,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	17,185,502.51	45,854,069.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	376,591,744.45	268,242,352.42
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	77,947,206.45	63,884,998.42
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	77,947,206.45	63,884,998.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,112,238.00	30,997,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,858,838.00	26,697,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,253,400.00	4,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,748,800.00	20,699,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,748,800.00	20,699,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	199,783,500.00	152,660,554.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	199,783,500.00	152,660,554.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	123,986,438.10	110,574,160.25
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,527.03	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	27,527.03	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(27,527.03)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	123,958,911.07	110,574,160.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,257,488,800.00	1,124,413,516.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,026,055,300.00	951,852,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,026,055,300.00	951,852,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,026,055,300.00	951,852,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,026,055,300.00	951,852,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	231,433,500.00	172,560,616.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	231,433,500.00	172,560,616.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,500,000.00	1,256,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	16,143,562.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	199,933,500.00	155,160,554.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,257,488,800.00	1,112,269,954.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,240,488,800.00	1,103,027,654.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,897,055.55	834,785,301.58
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	559,803,331.68	561,210,610.38
210101	Үндсэн цалин	413,536,966.38	397,651,392.26
210102	Нэмэгдэл	125,103,103.65	144,503,977.80
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	12,985,217.10	12,415,232.85
210104	Урамшуулал	8,178,044.55	6,640,007.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,293,632.87	74,035,701.20
210201	Тэтгэврийн даатгал	48,130,101.36	52,054,736.52
210202	Тэтгэмжийн даатгал	5,721,189.54	5,791,824.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,504,149.68	4,522,579.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,093,444.49	1,060,596.37
210205	Эрүүл мэндийн даатгал	10,844,747.80	10,605,964.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,638,622.00	45,549,014.00
210301	Гэрэл, цахилгаан	7,673,896.00	9,852,243.00
210302	Түлш, халаалт	22,315,600.00	19,806,431.00
210303	Цэвэр, бохир ус	1,979,926.00	2,221,140.00
210304	Байрны түрээс	13,669,200.00	13,669,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,059,893.00	54,707,650.00
210401	Бичиг хэрэг	10,353,800.00	9,648,320.00
210402	Тээвэр, шатахуун	35,260,000.00	33,760,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,494,580.00	8,242,260.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,200.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,863,313.00	2,963,470.00
2105	Нормативт зардал	18,500,170.00	11,970,710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,386,000.00	10,635,710.00

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	3,581,170.00	1,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	135,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,863,000.00	43,675,054.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	48,090,150.00	12,960,500.00
210604	Урсгал засвар	16,772,850.00	30,714,554.00
2107	Томилолт, зочны зардал	36,656,900.00	27,387,300.00
210702	Дотоод албан томилолт	36,656,900.00	27,387,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,053,106.00	15,141,062.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,217,800.00	12,000,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	122,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	272,550.00	295,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	737,266.00	487,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	792,000.00	814,462.00
210807	Газрын төлбөр	28,390.00	32,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,582,100.00	1,289,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,028,400.00	1,108,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,028,400.00	1,108,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	376,591,744.45	268,242,352.42
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	77,947,206.45	63,884,998.42
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	77,947,206.45	63,884,998.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,112,238.00	30,997,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,858,838.00	26,697,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,253,400.00	4,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,748,800.00	20,699,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,748,800.00	20,699,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	199,783,500.00	152,660,554.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	199,783,500.00	152,660,554.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	12,143,562.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,000,000.00	9,242,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,000,000.00	9,242,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,000,000.00	9,242,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,000,000.00	9,242,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,000,000.00)	(9,242,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	12,143,562.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	451,495,666.98	14,663,035.25	(309,363,540.66)	156,795,161.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	451,495,666.98	14,663,035.25	(309,363,540.66)	156,795,161.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	(1,893,652.34)	1,893,652.34	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	123,958,911.07	123,958,911.07
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	(183,510,977.25)	280,754,072.64
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	(183,510,977.25)	280,754,072.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	(183,510,977.25)	280,754,072.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	110,574,160.25	110,574,160.25
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	(72,936,817.00)	391,328,232.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	931,258,600.00	870,146,701.58	61,111,898.42	93.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	931,258,600.00	870,146,701.58	61,111,898.42	93.44
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,261,500.00	840,149,601.58	61,111,898.42	93.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	604,653,800.00	560,832,610.38	43,821,189.62	92.75
210101	Үндсэн цалин	434,808,100.00	397,651,392.26	37,156,707.74	91.45
210102	Нэмэгдэл цалин	143,481,700.00	144,503,977.80	-1,022,277.80	100.71
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	19,723,000.00	12,037,232.85	7,685,767.15	61.03
210104	Урамшуулал	6,641,000.00	6,640,007.47	992.53	99.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,628,200.00	74,035,701.20	7,592,498.80	90.70
210201	Тэтгэврийн даатгал	57,442,100.00	52,054,736.52	5,387,363.48	90.62
210202	Тэтгэмжийн даатгал	6,046,500.00	5,791,824.28	254,675.72	95.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,837,200.00	4,522,579.41	314,620.59	93.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,209,300.00	1,060,596.37	148,703.63	87.70
210205	Эрүүл мэндийн даатгал	12,093,100.00	10,605,964.62	1,487,135.38	87.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,376,600.00	45,549,014.00	2,827,586.00	94.16
210301	Гэрэл, цахилгаан	11,217,200.00	9,852,243.00	1,364,957.00	87.83
210302	Түлш, халаалт	19,942,300.00	19,806,431.00	135,869.00	99.32
210303	Цэвэр, бохир ус	3,547,900.00	2,221,140.00	1,326,760.00	62.60
210304	Байрны түрээс	13,669,200.00	13,669,200.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,387,400.00	51,207,650.00	1,179,750.00	97.75
210401	Бичиг хэрэг	10,353,800.00	9,648,320.00	705,480.00	93.19
210402	Тээвэр, шатахуун	30,260,800.00	30,260,000.00	800.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,715,700.00	8,242,260.00	473,440.00	94.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	93,600.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,963,500.00	2,963,470.00	30.00	100.00
2105	Нормативт зардал	12,369,000.00	11,970,710.00	398,290.00	96.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,636,000.00	10,635,710.00	290.00	100.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	135,000.00	398,000.00	25.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,965,500.00	52,917,354.00	48,146.00	99.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,250,000.00	9,242,300.00	7,700.00	99.92
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,000,000.00	12,960,500.00	39,500.00	99.70
210604	Урсгал засвар	30,715,500.00	30,714,554.00	946.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	31,070,300.00	27,387,300.00	3,683,000.00	88.15
210702	Дотоод албан томилолт	31,070,300.00	27,387,300.00	3,683,000.00	88.15
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,702,400.00	15,141,062.00	1,561,338.00	90.65

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,248,600.00	12,000,850.00	247,750.00	97.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	562,400.00	122,600.00	439,800.00	21.80
210803	Даатгалын үйлчилгээ	344,900.00	295,650.00	49,250.00	85.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	740,000.00	487,100.00	252,900.00	65.82
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	144,000.00	99,000.00	45,000.00	68.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,338,400.00	814,462.00	523,938.00	60.85
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,292,100.00	1,289,400.00	2,700.00	99.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,108,300.00	1,108,200.00	100.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,108,300.00	1,108,200.00	100.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,997,100.00	29,997,100.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,997,100.00	29,997,100.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,697,100.00	26,697,100.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	931,258,600.00	931,258,600.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	179,380,116.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,198,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4313,878,000.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	378,000.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	199,783,500.00	378,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	199,783,500.00	3,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,320,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,320,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	199,783,500.00	2,320,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	199,783,500.00	1,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	152,840,554.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	199,783,500.00	180,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	199,783,500.00	152,660,554.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	172,182,116.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	172,182,116.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	199,783,500.00	878,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	199,783,500.00	16,143,562.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	199,783,500.00	155,160,554.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	(7,198,000.00)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Цаашид Мэргэжлийн хяналтын газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт болон анхан шатны баримтын бүрдэл, ажил гүйлгээг батлагдсан загвар, аргачлалын дагуу бүртгэх, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Мэргэжлийн хяналтын газрын эрхэм зорилго нь “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт хуулийг сахиулан хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино.

Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн төлөв байдлын талаар олон нийтийг мэдээллээр хангах,
- Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах,
- Дотоод хяналтын соёл нэвтрүүлсэн байгууллагыг бэлтгэх,
- Лабораторийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах,

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн, биелэлт, үр дүнг тооцох,
- Үндэсний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээний биелэлтийг хангах.

4317143998
МЮА0065 9055436

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,233,972.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,339.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 8,637. 8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4317143998
5436

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 110,195.6 мянган төгрөгөөр буюу 39.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	799.4	799.4	-
Урьдчилгаа			
Бараа материал	172,126.5	164,904.1	(7,222.4)
Үндсэн хөрөнгө	108,206.7	225,624.8	117,418.1
Нийт хөрөнгө	281,132.6	391,328.2	110,195.6
Өр төлбөр	378.5	-	(378.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	280,754.1	391,328.2	110,574.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	281,132.6	391,328.2	110,195.6

Бараа материалын дансны үлдэгдэл 164,904.0 мянган төгрөг болж 7,222.4 мянган төгрөгөөр буурсан нь МХЕГ-аас 6,121.0 мянган төгрөгийн /нэг удаагийн маск, усны гутал үнэт цаас, нүүрний хаалт мананцаржуулагч, автомаск, халуун хэмжигч, ариутгагч салфетка, үнэт цаас/, аймгийн ЗДТГ-аас 700.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвийн хөрөнгөөр 75,800.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 89,844.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 871,871.7 мянган төгрөг болж өмнөх оноос 163,272.1 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Онцгой байдлын газраас 31,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий УАЗ-Фургон автомашин, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 46,832.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 48,000.0 мянган төгрөгийн улаан буудайн шинжилгээний аппарат зэргийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг 26,197.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, 8,177.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,064.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 391,328.2 мянган төгрөг болж 110,574.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 110,195.7 мянган төгрөгөөр буюу 39.2 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 160,850.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.



3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 931,258.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг өөрчлөлт оруулалгүйгээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 931,258.6 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 931,258.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 870,146.7 мянган төгрөгийг зарцуулан, тайлант оны эцэст үндсэн үйл ажиллагааны зардлаас 61,111.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 74.6 мянган төгрөг зэрэг нийт 61,186.5 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

2021 онд 20,594.3 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтээр МХЕГ-аас Ковид 19 цар тахлын үед ажилласан албан хаагчдын хоол, шатахууны зардалд 878.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал урамшуулалд 1,000.0 мянган төгрөг, шатахууны /хууль бус алт олборлолтын шалгалт / зардалд 3,000.0 мянган төгрөг тус тус төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант хугацаанд нийт 157,480.5 мянган төгрөгийг аймгийн төсвийн хүү торгуулийн орлогын данс болон улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ**”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон улсын байцаагч Ч. Алтангэрэлийн Хөтөлийн цемент шохойн комбинат, аймгийн төвлөрсөн дулааны станц /тухайн үеийн нэрээр/ зэрэг үйлдвэрийн газруудад ажиллаж байсан 19 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор МХЕГ-аас хянаж, ирүүлсний дагуу нийт 26,697.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Хөтөлийн цемент шохойн комбинат, аймгийн төвлөрсөн дулааны станц зэрэг үйлдвэрийн газрууд нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

3.7.2 Албан томилолтын удирдамжийг 3-7 суманд ажиллахаар боловсруулан томилолтын зардлыг олгосон боловч хууль бус уул уурхайд хийх хяналт шалгалтаар сумын төвөөс алслагдсан газруудаар ажилласан гэх шалтгаанаар зөвхөн 1 сумаар албан томилолтыг баталгаажуулан хавсаргасан байна. Цаашид албан томилолтын хуудсыг хүрч ажилласан бүх сумд, албан байгууллагаар баталгаажуулах нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мэргэжлийн хяналтын газар нь мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг /дараа жилийн төсвийн төсөл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл / хугацаа хоцроож, 6 мэдээллийг /төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан/ огт байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,760.7 мянган төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн биелүүлж, 18,315.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	1,760.7	1	1,760.7	100
Зөвлөмж	3	18,315.6	2	18,315.6	66.7
Нийт дүн	4	20,076.3	3	20,076.3	75.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа,

зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24,956.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 21,896.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2.1 Илрүүлэлт: 3,060.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын баримтын хоног хугацаа болон ажилласан жолоочийг давхардуулан тооцож, шатахуун олгосон байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид шатахуун зарцуулсан жолооч болон албан хаагч тус бүрээр анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

3.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан хугацаа, спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй, стандарт маягтаар хөтлөөгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан хугацаа, спидометрийн заалтыг бүрэн бүртгэж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын	4	24,956.8	-	-	-	-	1	-	3	24,956.8